

ХАВСРАЛТ 1

Зүүн хойд Ази дахь шар шороон шуургаанаас урьдчилан сэргийлэх болон хянах техникийн туслалцааны төсөл (RETA 6068)

(Японы тусгай сан болон Даян Дэлхийн Байгаль Орчны Сан хамтран санхүүжүүлнэ)

А. Зорилго ба үр дүн

Техникийн туслалцааны (ТТ) зорилго нь Шар шороон шуурга (ШШШ)-наас урьдчилан сэргийлэх болон хянах бүс нутгийн хамтын ажиллагааны механизмыг бий болгохыг дэмжих, бүс нутаг дахь холбогдох талуудын үйл ажиллагааг зохицуулах, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх явдал юм.

ТТ-ны гол үр дүн нь (1-рт) бүс нутгийн түвшинд ШШШ-тай холбогдох бүх талын дунд олон улсын бодлого үйл ажиллагааны зохицуулалтыг бий болгох бүс нутгийн бүтцийн хүрээг бий болгох, (2-рт) шинжлэх ухааны судалгааны үр дүнгийн дэлгэрэнгүй үнэлгээн дээр үндэслэсэн ШШШ-ыг багасгах бүс нутгийн мастер төлөвлөгөөг боловсруулах явдал юм. Энэ мастер төлөвлөгөө нь (1-рт) ШШШ-ыг хянах, урьдчилан мэдээлэх бүс нутгийн сүлжээг бий болгох үе шаттай хөтөлбөр, (2-рт) санхүүжилтийн тогтвортой механизмын талаарх зөвлөмжүүд болон ШШШ-ны эх үндсэн шалтгаанд нөлөөлөх хамгийн сайн туршлагаудыг түгээн дэлгэрүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий найман (БНХАУ-д дөрөв, Монгол Улсад дөрөв) загвар төслийг тодорхойлох зэргийг багтаасан хөрөнгө оруулалтын стратегитай юм.

Б. Арга зүй болон гол үйл ажиллагаа

Энэ ТТ нь бүс нутаг дахь холбогдох талууд болох Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Япон, Бүгд Найрамдах Солонгос Улс, Монгол Улсын Засгийн газрууд, олон улсын дөрвөн байгууллага: АХБ, НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын ЦТК, НҮБ-ын БОХ зэргийн хамтарсан хүчин чармайлт дээр тулгуурлан хэрэгжих юм. Эдгээр дөрвөн Засгийн газар болон дөрвөн байгууллагыг хамтад нь оролцогч талууд хэмээн нэрлэнэ. ТТ-ны хүрээнд хэрэгжих гол үйл ажиллагаа нь үндсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгт хуваагдах ба эдгээр нь ШШШ-ны эсрэг бүс нутгийн хамтын ажиллагааны бүтцийн хүрээг бий болгох болон ШШШ-ыг бууруулах бүс нутгийн хамтын ажиллагааны мастер төлөвлөгөөг боловсруулах явдал болно.

Бүтцийн хүрээг бий болгох. ШШШ-ны эсрэг бүс нутгийн хамтын ажиллагааны бүтцийн хүрээг бий болгохдоо оролцогч талууд БНХАУ болон Монгол Улсын хамтран даргалах удирдах хороог байгуулах юм. Энэ хороо нь ТТ-ны хэрэгжилтийг ерөнхийд нь удирдах юм. Удирдах хорооны дор оролцогч талууд техникийн гурван хороог байгуулах ба бүс нутгийн хамтын ажиллагааны механизмыг дэмжих хороог НҮБ-ын ЦТК, шинжлэх ухааны судалгааны үр дүнд дэлгэрэнгүй үнэлэлт өгөх, ШШШ-ыг хянах, урьдчилан мэдээлэх бүс нутгийн сүлжээг байгуулах үе шаттай хөтөлбөр боловсруулах хороог НҮБ-ын БОХ,

ШШШ-ны эх үүсвэр нутгуудад түүнийг бууруулах арга хэмжээний хөрөнгө оруулалтын стратеги боловсруулах хороог НҮБ-ын АНДЭЗНК даргална. Техникийн хороодын гишүүнчлэл нь бүх оролцогч талууд болон бүс нутаг дахь ШШ-ыг бууруулахад техникийн болон санхүүгийн хувьд хувь нэмэр оруулж чадах бусад орнууд болон байгууллагуудад нээлттэй байна.

ШШШ-д өртдөг орнуудыг болон олон улсын байгууллагуудыг бүс нутгийн хамтын ажиллагааны механизмд татан оролцуулснаараа энэхүү ТТ нь ШШШ-ны эх үүсвэр болдог, түүний хор уршигт өртдөг орнуудыг оролцуулсан ШШШ-ыг хянах, урьдчилан мэдээлэх стандартчилсан системийг байгуулахад туслалцаа үзүүлэх юм. ТТ нь мөн БНХАУ болон Монгол Улсын зүгээс ШШШ-ны эх үүсвэр нутгуудад авч хэрэгжүүлж буй арга хэмжээн дээр нэмээд ШШШ-нд өртдөг орнууд, олон улсын байгууллагууд, бусад холбогдох талуудын техникийн, санхүүгийн болон үйл ажиллагааны дэмжлэгийг дайчлахад туслалцаа үзүүлнэ. Анхны бий болгож буй энэхүү бүтцийн хүрээ нь холбогдох талуудад ШШШ-ны эсрэг бүс нутгийн хамтын ажиллагааны илүү тогтвортой, ТТ-ны хэрэгжилтийн хугацаагаар хязгаарлагдахгүй оршин тогтнох байнгын бүтцийг бий болгох механизм болж өгөх юм.

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдэх үндсэн үйл ажиллагаа нь (1-рт) удирдах хороог байгуулж, бодлогоо зөвлөлдөх, шийдвэр гаргах зорилгоор удирдах хорооны нэгдсэн хуралдааныг дөрвөөс доошгүй удаа зохион байгуулах, (2-рт) техникийн гурван хороог байгуулж, техникийн зөвлөгөө, чиглэл өгөх зорилгоор техникийн хороо тус бүрийн нэгдсэн хуралдааныг дөрвөөс доошгүй удаа зохион байгуулах, (3-рт) ТТ-ны хэрэгжилтэнд тус нэмэр үзүүлэх зорилгоор үйл ажиллагааны зохицуулалтын болон захиргааны дэмжлэг үзүүлдэг төслийн нарийн бичгийн дарга нарын газрыг удирдах хорооны удирдлага дор байгуулах, (4-рт) ШШШ-ны мэдээллийн компьютержсэн санг оролцогч талуудад зориулан бий болгож, ажиллуулах, (5-рт) ШШШ-ны талаарх олон нийтийн ойлголтыг бэхжүүлж, ШШШ-ыг багасгахад олон нийтийн дэмжлэгийг авахын тулд төслийн вэбсайт болон мультимедиа танилцуулгаар дамжуулан олон нийтэд ойлгуулах хөтөлбөр эхлүүлэх, хэрэгжүүлэх зэрэг болно.

Мастер төлөвлөгөө боловсруулах. Оролцогчдын зөвлөлдөөний үндсэн дээр ШШШ-ыг бууруулах бүс нутгийн хамтын ажиллагааны мастер төлөвлөгөөг боловсруулна. Мастер төлөвлөгөөний тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдийг холбогдох техникийн хороодоор хэлэлцэх ба удирдах хороо батална. Боловсруулах үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөөнүүд болон олон нийтэд ойлгуулах хөтөлбөрийн хүрээнд ажиллах тусгай вэбсайтаар дамжуулан олон нийтийн оролцоог илүү хялбар болгох юм. ШШШ-ыг хянах, урьдчилан мэдээлэх бүс нутгийн сүлжээг байгуулах үе шаттай хөтөлбөрийг боловсруулах үйл ажиллагаа нь (1-рт) хөтөлбөрийг боловсруулахдаа хөндөх ёстой асуудлыг тодорхойлох зорилгоор үндэсний түвшний хянах, урьдчилан мэдээлэх системийг авч үзэх олон улсын зөвлөгөөнийг зохион байгуулах, (2-рт) хөтөлбөрийн төслийг боловсруулах зөвлөгчдийн багийг гаргаж ажиллуулах, (3-рт) техникийн тойм болон боловсруулах үйл явцын хоёр зөвлөгөөнийг зохион байгуулах, (4-рт) сонгож авсан ШШШ-ны хяналтын цэгүүдэд албан ёсны судалгаа, танилцах аялал хийх зэргийг багтааж байна.

Мастер төлөвлөгөө болон хөрөнгө оруулалтын стратегийг боловсруулахдаа ШШШ-тай тэмцэх бүс нутгийн хамтын ажиллагааны тогтвортой байдлыг бэхжүүлэхэд төрийн ба хувийн хэвшлийн холбогдох талууд, иргэдийн дэмжлэгийг авах санхүүжилтийн шинэлэг механизмыг судалж үзэхэд анхаарах юм. Хөрөнгө оруулалтын стратегийг боловсруулахдаа ШШШ-ны эх үүсвэр нутгуудад амьдарч буй хүн амын амьжиргааг дээшлүүлэх байгаль орчинд халгүй ажлын байр санал болгох хамгийн сайн практикийг түгээн дэлгэрүүлэхэд гол анхаарал тавина. Үүнийг ядуурлыг бууруулах, ШШШ-ыг багасгахад аль алинд нь үр нөлөөтэй нь харагдсан амжилттай загвар төслийн туршлагыг нэвтрүүлэх, дэмжих замаар хэрэгжүүлнэ. Гол үйл ажиллагаа нь: (1-рт) мастер төлөвлөгөө болон хөрөнгө оруулалтын стратегийн төслийг боловсруулах зөвлөгчдийн багийг гаргаж ажиллуулах, (2-рт) техникийн тойм болон боловсруулах үйл явцыг дэмжих, сайн практик туршлагауудыг танилцуулах хоёр зөвлөгөөнийг зохион байгуулах, (3-рт) хамгийн сайн практик туршлага болон тохиромжтой загвар төслийг тодорхойлох зорилгоор ШШШ-ны эх үүсвэр нутгуудад хэрэгжих буй загвар ба цөлжилтийн эсрэг төслүүдтэй танилцах аялалыг албан тушаалтнуудад зориулан зохион байгуулах, (4-рт) технологи шилжүүлэх, туршлага солилцох зорилгоор олон улсын хамгийн сайн практик туршлагыг танилцуулах олон улсын мэргэжилтнүүдийг зөвлөгөөнд урьж оролцуулах зэрэг болно.

В. Өртөг ба санхүүжилт

Энэхүү ТТ-ны нийт өртөг нь 1,215,000 ам.доллартай тэнцэх ба үүний 745,000 нь гадаад валютаар, 470,000 нь орон нутгийн мөнгөөр гарах юм. АХБ нь нийт 500,000 ам.доллар гаргах ба энэ нь гадаад валютаар гарах зардлын 426,400 ам.доллар, орон нутгийн мөнгөөр гарах зардлын 73,600 ам.доллартай тэнцэх хэсгийг бүрэлдүүлж байна. Энэхүү ТТ-ны өртөг зардал нь Японы Засгийн газрын санхүүжилттэй Японы тусгай сангаас буцалтгүй тусламж байдлаар санхүүжих юм.

ТТ-ны хамтран санхүүжүүлэгч нь ДДБОС бөгөөд тус байгууллагын буцалтгүй тусламж хэлбэрээр гаргаж буй 500,000 ам.долларын 318,600 ам.доллар нь гадаад валютаар гарах зардалд, үлдсэн нь орон нутгийн мөнгөөр гарах зардлын 181,400 ам.доллартай тэнцэх хэсгийг бүрэлдүүлж байна. БНХАУ-ын болон Монгол Улсын Засгийн газрууд тус бүр 125,000 ам.доллар болон 90,000 ам.доллартай тэнцэх зардлыг тухайн улсын талын оролцогчдын үйлчилгээ, оффисын зардлыг санхүүжүүлэх байдлаар гаргаж байгаа юм.

Г. Хэрэгжилтийн асуудлууд

Энэхүү ТТ нь 2003 оны 01-р сараас эхлэн 2004 оны 06-р сарыг дуустал 18 сарын хугацаанд хэрэгжинэ. АХБ нь энэ ТТ-ны ерөнхий менежмент, удирдлагыг хариуцах Гүйцэтгэх Агентлаг юм. ТТ-ыг НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын ЦТК, НҮБ-ын БОХ хамтран хэрэгжүүлнэ. ДДБОС-гийн хамтарсан санхүүжилтэнд гаргаж буй хөрөнгийг хариуцсан ДДБОС-гийн хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг гүйцэтгэж байгаа НҮБ-ын БОХ нь шинжлэх ухааны сулалгааны үр дүнд дэлгэрэнгүй үнэлгээ өгөх, ШШШ-ыг хянах, урьдчилан мэдээлэх бүс нутгийн сүлжээг байгуулах хөтөлбөр боловсруулах техникийн хороог даргална. Үүнтэй холбогдуулан, НҮБ-ын БОХ нь ТТ-ны төсөлд оруулж буй өөрийн хувь нэмэр

болгон 12 хүн сарын мэргэжлийн үйлчилгээ болон оффисыг үнэ төлбөргүй гаргаж байгаа юм. Техникийн зохицуулалтын хамтран хэрэгжүүлэгч агентлагын үүрэг гүйцэтгэж байгаа НҮБ-ын АНДЭЗНК нь хөрөнгө оруулалтын стратеги боловсруулах техникийн хороог даргална. НҮБ-ын АНДЭЗНК нь 10 хүн сарын мэргэжлийн үйлчилгээний хувь нэмэр оруулж байна. ТТ нь НҮБ-ын ЦТК-той хамтран удирдах хороо болон Гүйцэтгэх Агентлаг АХБ-инд үйл ажиллагааны болон захиргааны дэмжлэг үзүүлэх төслийн нарийн бичгийн дарга нарын газрыг байгуулна. Үүнтэй холбогдуулан, НҮБ-ын ЦТК нь төслийн нарийн бичгийн дарга нарын газарт зориулж 18 хүн сарын мэргэжлийн үйлчилгээ болон оффисыг үнэ төлбөргүй гаргана. НҮБ-ын гурван агентлаг болох АНДЭЗНК, ЦТК болон БОХ нь ТТ-г дэмжихийн тулд өөрсдийн нөлөө болон туршлагаа ашиглан нэмэлт техникийн болон санхүүгийн эх үүсвэрийг дайчлахад хүчин чармайлт гаргана.

БНХАУ-ын Засгийн газар өөрийн Улсын Хөгжлийн Төлөвлөлтийн Комиссийг ТТ-ны төслийн үндэсний зохицуулах агентлаг байхаар томилсон байна. БНХАУ-ын Засгийн газар нь ТТ-г чиглүүлэх, дэмжих зорилготой Улсын Хөгжлийн Төлөвлөлтийн Комисс, Сангийн Яам, Улсын Байгаль Орчныг Хамгаалах Газар, Улсын Ойн Аж Ахуйн Газар зэрэг олон агентлагийн төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулсан байна. Монгол Улсын Засгийн Газар ТТ-ны үндэсний зохицуулах агентлагаар Байгаль Орчны Яамыг томилжээ. Харин ТТ-ны үйл ажиллагааг чиглүүлэх, дэмжихэд Байгаль Орчны Яам, Санхүү Эдийн Засгийн Яам болон бусад холбогдох агентлагын төлөөлөгчид оролцоно.

Энэ ТТ нь бодлого болон стратеги төлөвлөлт, ШШШ-ыг хянах, бууруулах, цөлжилттэй тэмцэх, олон улсын хөрөнгө оруулалтын чиглэлээр 11 орчим хүн сарын олон улсын консалтингийн үйлчилгээг шаардана. Мөн ТТ-ны хүрээнд БНХАУ болон Монгол Улсаас стратеги төлөвлөлт, ШШШ-ыг газраас хянах, алсаас мэдрэх, элсэрхэг хөрсийг ургамалжуулах, байгаль орчны менежментийн чиглэлээр 42 орчим хүн сарын дотоодын үйлчилгээ шаардагдах юм. Эдгээр зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх зөвлөгчдийг АХБ өөрийн Зөвлөгчдийн үйлчилгээг ашиглах журам болон дотоодын зөвлөгчдийг сонгож ажиллуулах бусад зааврын дагуу хувь хүмүүсээс сонгоно.

Техникийн туслалцааны логикийн хүрээ

Бүтцийн тойм	Үйл ажиллагааны үзүүлэлт болон хүрэх үр дүн	Хяналтын механизм	Таамаглал ба эрсдэл
Зорилго Зүүн хойд Ази дахь шар шороон шуурга (ШШШ) хэмээх хил дамнансан байгалийн үзэгдлийн давтамж, хүч, хор уршгийг бүс нутгийн хамтын ажиллагаагаар дамжуулан бууруулах	Хянах, урьдчилан мэдээлэх бүс нутгийн үр дүнтэй сүлжээг нэвтрүүлэн хор уршгийг бууруулах Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) болон Монгол Улс дахь ШШШ-ны эх үүсвэр нутгуудын хөрсний элэгдэл доройтлын асуудлыг шийдвэрлэх замаар ШШШ-ны давтамж болон хүчийг багасгах	ШШШ-ыг хянах болон хор уршгийн тайланг авах явдлыг үргэлжлүүлэх Хөрсний элэгдэл доройтлын тайлан болон ШШШ-ны эх үүсвэр нутгуудад гарч буй сайжралын тайланг тогтмол авах замаар хяналтыг үргэлжлүүлэх	ШШШ-ны дамтамж, хүч, хор уршгийг нь сайн төлөвлөж, зохицуулсан арга хэмжээний дүнд бууруулж болно. ШШШ-ны эх үүсвэр нутгуудын хөрсний элэгдэл доройтол нь бүс нутаг дахь ШШШ нэмэгдэж байгаагийн нэг гол шалтгаан мөн.
Зорилт Бүс нутгийн түвшинд холбогдох талуудын харилцан уялдаатай үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, туслах зорилгоор Зүүн хойд Ази дахь ШШШ-наас урьдчилан сэргийлэх,	ШШШ-тай тэмцэхэд холбогдох талуудын дэмжлэгийг авах, ШШШ-ны эсрэг арга хэмжээг уялдуулан эрхицуулах үйл ажиллагааны чадавхи бүхий бүс нутгийн хамтын ажиллагааны механизмыг бий болгох (1-рт) ШШШ-ыг хянах, урьдчилан	Бүх оролцогч талууд (БНХАУ, Япон, БНСУ, Монгол Улс, Азийн Хөгжлийн Банк (АХБ), НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенц (ЦТК), НҮБ-ын Ази Номхон далайн Эдийн засаг нийгмийн комисс (АНДЭЗНК)) төслийн хэрэгжилтийн ерөнхий удирдлага чиглэлээр	Бүх дөрвөн орон дөрвүүлээ бүс нутгийн хамтын ажиллагаагаар дамжуулан ШШШ-ны асуудлыг шийдвэрлэх улс төрийн хүсэл эрмэлзэлтэй, бодлогын хувьд тууштай байна.

Бүтцийн тойм	Үйл ажиллагааны үзүүлэлт болон хүрэх үр дүн	Хяналтын механизм	Таамаглал ба эрсдэл
<p>хянах бүс нутгийн хамтын ажиллагааны механизмыг бий болгох явдлыг дэмжих</p>	<p>мэдээлэх бүс нутгийн сүлжээг бий болгох үе шаттай хөтөлбөр, (2-рт) санхүүжилтийн тогтвортой механизмийн талаарх зөвлөмж болон найман загвар төслийг тодорхойлсон хөрөнгө оруулалтын стратегийг багтаасан ШШШ-тай тэмцэх бүс нутгийн мастер төлөвлөгөөг боловсруулах</p>	<p>хангах удирдах хороог байгуулна.</p> <p>Техникийн туслалцаа (ТТ)-ны хэрэгжилтийн үеийн техник асуудлаар зөвлөгөө өгөх техникийн гурван хороог талууд байгуулна.</p>	<p>Олон улсын дөрвөн байгууллага тууштай хамтран ажиллана.</p>
<p>Үр дүн ШШШ-ны асуудлаарх бүс нутгийн хамтын ажиллагааны бүтцийн хүрээ</p> <p>Дараах зүйлсийг багтаасан бүс нутгийн хамтын ажиллагааны мастер төлөвлөгөө. Үүнд: (1-рт) ШШШ-ыг хянах, урьдчилан мэдээлэх бүс нутгийн сүлжээг бий болгох үе шаттай хөтөлбөр, (2-рт) санхүүжилтийн тогтвортой механизмийн талаарх зөвлөмж болон БНХАУ-д дөрөв, Монгол Улсад дөрөв, нийт найман загвар төслийг тодорхойлсон хөрөнгө оруулалтын стратеги</p>	<p>Бүтцийн хүрээ бий болсноор ШШШ-ийг холбогдох гол талуудад өөрсдийн бодлого болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээ уялдуулан зохицуулах механизм бий болж байгаа юм.</p> <p>Мастер төлөвлөгөөг удирдах хороо батална.</p>	<p>Бүтцийн хүрээний бүхий л үйл ажиллагааг удирдах хороогоор дамжуулан холбогдох талууд ойроос хянана.</p> <p>Мастер төлөвлөгөөг шинжлэх ухааны судалгааны үр дүнгийн дэлгэрэнгүй үнэлгээн дээр үндэслэн үндэсний олон агентлагийн төлөөлөл бүхий ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, БНХАУ болон Монгол Улсын үндэсний зохицуулах агентлагуудын удирдлагын дор боловсруулна. Удирдах хороонд оруулахаас өмнө холбогдох техникийн хороодоор хэлэлцэгдэнэ.</p>	<p>Удирдах хороо нь холбогдох Засгийн газруудын өмнөөс бодлогын болон үйл ажиллагааны асуудлаар шийдвэр гаргана.</p> <p>Холбогдох техникийн хороод нь техникийн зөвлөгөө ба чиглэл өгөх чадвартай.</p>
<p>Үйл ажиллагаа</p> <p>Дараах зүйлсийг бий болгох, үүнд: ШШШ-тай тэмцэх бүс нутгийн хамтын ажиллагааны бүтцийн хүрээ</p> <p>ШШШ-ны бүс нутгийн мэдээллийн сан Олон нийтэд ойлгуулах хөтөлбөрийн хүрээнд ТТ-нд зориулсан вэбсайт</p> <p>Дараах зүйлсийг судалж, анализ хийх ШШШ-ны талаарх шинжлэх ухааны судалгааны одоо байгаа үр дүн болон бүс нутаг дахь ШШШ-ыг хянах, урьдчилан мэдээлэх одоогийн байгаа систем ШШШ-ны талаар авч хэрэгжүүлж буй үндэсний хөтөлбөрүүд, БНХАУ болон Монгол Улс дахь үндэсний туршилт, загвар төслүүд ШШШ-ыг бууруулах хамгийн сайн туршлагауд</p> <p>Хувийн хэвшил болон ТББ-уудын санаачилга</p> <p>Бүс нутгийн түвшин дэх хамтын ажиллагаагаар дамжуулан ШШШ-ыг бууруулах бүс нутгийн</p>	<p>Бүтцийн хүрээ болон олон нийтийн мэдээлэлд зориулсан вэбсайт нь техникийн туслалцаа (ТТ) батлагдснаас хойш нэг сарын дотор үйл ажиллагаагаа эхэлсэн байх ёстой.</p> <p>Бүх үйл ажиллагааны нарийвчилсан ажлын төлөвлөгөө нь хамгийн анхны хурлаар холбогдох техникийн хороодоор хэлэлцэгдэх, удирдах хороогоор батлагдахад бэлэн байх ёстой.</p> <p>Судалгаа, анализийн үр дүн нь холбогдох техникийн хороодоор цаг тухайдаа хэлэлцэгдэхэд бэлэн байх ёстой.</p>	<p>Ажлын хөтөлбөрийг холбогдох техникийн хороод хянаж, удирдах хороо батална.</p> <p>Зөвлөгчид долоо хоног тутмын тайлангаа төслийн нарийн бичгийн дарга нарын газар болон АХБ-инд өгнө.</p> <p>Төслийн нарийн бичгийн дарга нарын газар нь сар тутмын тайлангаа АХБ, үндэсний зохицуулах агентлагууд, удирдах хороонд өгнө.</p> <p>Төслийн нарийн бичгийн дарга нарын газар нь мэдээлэл түгээх, олон нийтэд ойлгуулах, хяналттай байлгах зорилгоор мэдээллийн сэтгүүл гаргана.</p>	<p>Засгийн газрууд судалгаа хийх зорилгоор мэдээ мэдээлэл, бичиг баримттай танилцах боломжийг зөвлөгчдөд олгоно.</p> <p>Төслийн нарийн бичгийн дарга нарын газар нь орон нутагт төслийн газарт явагдаж буй үйл ажиллагааг хянах, туслах үйл ажиллагааны болон захиргааны туслалцаа үзүүлэх боломжтой байна.</p>

6 ХАВСРАЛТ 1

Бүтцийн тойм	Үйл ажиллагааны үзүүлэлт болон хүрэх үр дүн	Хяналтын механизм	Таамаглал ба эрсдэл
<p>мастер төлөвлөгөөг зөвлөмж болгох. Энэхүү мастер төлөвлөгөө нь ШШШ-ыг хянах, урьдчилан мэдээлэх бүс нутгийн сүлжээ байгуулах үе шаттай хөтөлбөр</p> <p>Санхүүжилтийн тогтвортой механизмын талаарх зөвлөмж, 8 загвар төслийг (БНХАУ-д 4, Монгол Улсад 4) тодорхойлох зэргийг багтаасан байна.</p>			